



**ХАЛДВАРТ ӨВЧИН  
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар A/190

Улаанбаатар хот

**Сахилга хариуцлага, дэг журмыг  
сайжруулж ажиллах тухай**

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах тухай” 33 дугаар тогтоол, Төвийн ерөнхий захирлын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай” A/190 дүгээр тушаал зэргийг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн ажлынхаа давуутай талыг ашиглан ажил олгогчоос хүлээлгэсэн итгэлийг хувийн ашиг сонирхолд урвуулан ашиглах, шаардлагатай эм, оношлуур, эмнэлгийн тусламжийн материалыг хувийн зорилгоор ашиглах, мэргэжлийн давуу талыг ашиглан төлбөр авах, хууран мэхлэх, залилах зэрэг асуудалд анхаарч ажиллахыг холбогдох ажилтнуудад үүрэг болгосугай.

2. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахиж өөрийгөө болон бусдыг халдвар авахаас урьдчилан сэргийлж ажиллахыг нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, хэрэглэсэн байдлаар ирэх, бусдыг өдөөн хатгах, архи уусан ажилтныг нуун дарагдуулах, ажлын байр болон ажлын орчинд тамхи татах асуудлыг 100

хувь зогсоож өөрийгөө болон бусдыг хордуулахаас урьдчилан сэргийлж, тогтмол хяналт тавьж ажиллахыг салбар хариуцсан дэд захирал, албадын дарга, тасгийн эрхлэгч, нэгжийн дарга, хүний нөөцийн менежер нарт тус тус үүрэг болгосугай.

4. Хариуцсан салбар, алба, тасаг, нэгжийн ажилчдын ажлын байрны чиг үүргийн давхардал, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, хүнд сурталгүй, чирэгдэлгүй ажиллах, ажлын цаг ашиглалт, ажлын байрны дэг журмыг сайжруулж ажиллахыг салбар хариуцсан дэд захирал, албадын дарга, тасгийн эрхлэгч, нэгжийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин, хөдөлмөрийн гэрээ, сахилга хариуцлагын гэрээ, холбогдох дүрэм журмаар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

6. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн гэрээ, сахилга хариуцлагын гэрээ, холбогдох дүрэм журам, энэхүү тушаалыг зөрчсөн ажилчдад зөрчил гаргасан шинж байдлыг нь харгалзан үзэж зохих журмын дагуу сахилгын шийтгэлийг ногдуулж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга (И.Орхон)-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцыг 7 хоног бүр Ерөнхий захиралд танилцуулж ажиллахыг Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Бурмаа)-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.БАТТӨР